Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# “ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ** | | | | | | | | |
| **1.1.** 1.1 ЗГҮАХ 3.2.2.11 Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийг бүрэн ашиглалтад оруулна. | | | | | | | | |
| 1.1.1 | “Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-г баталгаажуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл хувиар | 66.6% | 100% | -БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Ардын Засгийн газартай “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн “Хамтран хөгжүүлэх төлөвлөгөөний төсөл”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. | 100% | 100 |
| 1.1.2 | **“**Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг хооронд нь хил дамнасан байгууламжаар холбох, улсын хилийг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл, хувиар | 66.6% | 100% | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааны танхимаас БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамаар дамжуулан 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн удирдлагын зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр тус тус “Хамтын ажиллагааны бүсийн (Хятад тал) хил дамнасан гол гарцын бүтээн байгуулалтын төлөвлөгөө”-нд тусгагдсан гол замын бүтцэд өөрчлөлт оруулах буюу замын өргөнийг 50 метр байсныг 40 метр болгон өөрчлөх саналыг ирүүлсэн. /Өөрчлөлтийг товч утга: Автозамын гол зорчих, нэвтрэх хэсэгт өөрчлөлт ороогүй бөгөөд хоёр | 100% | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талын ногоон байгууламж, тусгаарлах зурвас хэсгийн өргөнийг хассан./<br>Уг саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Зам тээврийн яам, гадаад харилцааны яам зэрэг холбогдох байгууллагуудыг саналыг үндэслэн Шадар сайдын ажлын албанаас саналыг дэмжсэн талаарх мэдээллийг Гадаад харилцааны яамаар дамжуулан хүргүүлсэн.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааны танхимаас ирүүлсэн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн эргэлтийн цэгүүдийн солбицлыг Монгол улсад мөрдөгдөж буй солбицлын тогтолцоонд хөрвүүлэх, санал авах талаар 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт албан бичиг хүргүүлсэн.<br>“Замын-Үүд Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн ээлжит хуралдааныг 2025 оны 10 дугаар 28-30-ны өдрүүдэд Монгол улсад зохион байгуулж, хурлаар “Гол гарцын бүтээн байгуулалтын төлөвлөгөө”-г эрчимжүүлэх талаар хоёр тал санал нэгдэж, протоколд тусгасан.<br>2025 оын 11 дүгээр сарын 19-ны өдөр “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчаас Гадаад харилцааны яаманд “Хамтын ажиллагааны бүс”-ийн хил хоорондын бүсэд гаалийн байгууллага, хил хамгаалах байгууллага, гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн байгууллагуудын хяналт, шалгалт, бүртгэх хамтын механизмыг бий болгож, харилцан мэдээлэл солилцох платформыг хөгжүүлэх, нэвтрүүлэх талаарх саналыг БНХАУ-ын талд тавих хүсэлтийг хүргүүлсэн.<br>2025 оны 12 дугаар сарын 12-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааны танхимаас БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамаар дамжуулан “Гол гарцын бүтээн байгуулалтын төлөвлөгөө”-нд өөрчлөлт | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оруулж, сайжруулсан төсөлд санал авахаар ирүүлснийг Гадаад харилцааны яамнаас Шадар сайдын ажлын алба, Захирагчийн ажлын албанд 2025.12.12-нд ирүүлж бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
| 1.1.3 | “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн Хамтарсан менежментийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хурлын тоо | - | 3 | Гадаад харилцааны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/74 дугаар тушаалаар байгуулсан Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан менежментийн зөвлөлийн анхдугаар хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 10-ны өдрийн хооронд Замын-Үүд суманд томилолтоор ажиллаж, 09-ний өдөр хурлыг 100 хувийн ирцтэйгээр зохион байгуулсан.<br>-Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан менежментийн зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан зөвлөлийн гишүүдээс санал авч нэгтгэх батлуулав. | 33% | 33 |
| 1.1.4 | “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хоёрдугаар хуралдааныг Монгол Улсад зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэх зөвлөлийн даргад хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Танилцуулсан эсэх Тийм 1/ үгүй 0 | - | 1 | Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн “Арга хэмжээ зохион байгуулах тухай” 154 дүгээр тушаалыг үндэслэн Монгол , Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хоёрдугаар хуралдааныг Шадар Сайдын ажлын албатай хамтран 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. | 100% | 100 |
| 1.1.5 | Монгол, Хятадын “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалтыг дэмжих форумыг Эрээн хотын Ардын Засгийн | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээ, тоо | - | 1 | “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн төлөөллийг БНХАУ-ын Танжин хотын бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй холбох, хамтран хөрөнгө оруулалт хийх талаар уулзалтыг 2025 оны 07 дугаар сарын 02-оос 07-ны өдрийн хооронд зохион байгуулав. | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газартай хамтран зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллах | | | | | | | |
| 1.1.6 | АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн Зорилт-1 /CS01 Дэд бүтэц болон барилга байгууламж барьж ашиглалтад оруулах;<br>Зорилт-2 /CS02/ Тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих;<br>Зорилт-3 /CS03/-ын Чөлөөт бүсэд нэвтрэх системийг байгуулах. /Олон чөлөөт бүсийн хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоог боловсруулах/ зөвлөх компанийн тайланд санал зөвлөмж өгөх | Гадаадын зээл тусламж | Тайлан тоо | - | 13 | **Зорилт-1 /CS01 Дэд бүтэц болон барилга байгууламж барьж ашиглалтад оруулах.**<br>- “Замын-Үүд сумтай холбох 1-р үе шатны авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл”, “Гадна тохижилт, ландшафтын зураг төсөл” тайланг баталгаажуулж, тендер зарлагдсан.<br>- “Замын-Үүд” чөлөөт бүсийн эхний ээлжийн 300 га газрын хоёрдугаар хэлхээний дулаан, цэвэр, бохир, цахилгаан холбооны шугам сүлжээний зураг төсөл, БОНҮ-ний тайланг баталгаажуулан тендер зарлагдаж, гүйцэтгэгчтэй 2025.09.22-нд гэрээ байгуулсан.<br>**Зорилт-2 /CS02/ Тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих;**<br>- Монгол Улсын Их хурлын 2024 оны 81 дүгээр тогтоолын дагуу “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх” төслийн ЗҮ-02: Менежментийн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч Хамтарсан консорциумын Монгол дахь түнш, "Боловсрол, Нийгмийн хөгжлийн төв" ТББ-д 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр, төсөл хэрэгжүүлэх нэгжийн мэдээлэл технологийн зөвлөх, хуулийн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч хувь зөвлөхүүдэд 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр тус тус Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн чиглэлийг танилцуулан гэрээг цуцлах болсон тухай урьдчилан танилцуулж, төслийн хүрээнд үргэлжилж буй тайлант ажлыг дуусгавар болгон баталгаажуулсан.<br>**Зорилт-3 /CS03/-ын Чөлөөт бүсэд нэвтрэх системийг байгуулах. /Олон чөлөөт бүсийн хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоог боловсруулах/** | 76% | 61,5 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Эхлэлийн тайлан - 2024.11.10<br>- Систем шинжилгээ, загварчлалын тайлан 2025.02.25<br>- Бета хувилбарын тайлан - 2025.04.18<br>- Бета хувилбараас Хувилбар 1 рүү шинэчлэх - 2025.04.18<br>- Нэгдсэн тайлан, Төслийн баримт бичиг - 2024.05.18<br>тус тус баталгаажуулж, системийг чөлөөт бүсийн үйл ажиллагаанд ашиглагдаж байна.<br><br>**2025 оны жилийн эцсийн байдлаар "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн хэрэгжилт**<br>-Зорилт-1 /CS01 Дэд бүтэц болон барилга байгууламж барьж ашиглалтад оруулах – 18.50 %<br><br>-Зорилт-2 /CS02/ Тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих – 50 %<br><br>-Зорилт-3 /CS03/-ын Чөлөөт бүсэд нэвтрэх системийг байгуулах – 100 %<br><br>Нийт гүйцэтгэл 54 % тай үргэлжилж байна.<br>-Нийт 13 тайлан<br>-Биелсэн 8 тайлан<br>-Цуцлагдсан 4 тайлан<br>-Хүлээгдэж буй 1 тайлан | | |
| 1.1.7 | "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийгдсэн дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын байгууламж, шугам сүлжээний ашиглалт үйл ажиллагааг жигдрүүлэхэд | Үйл ажиллагааны зардлаар | Санал боловсруулж хүргүүлсэн эсэх (Тийм: 1 / Үгүй: 0) | - | 1 | Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 42 дугаар тушаалаар "Замын-Үүдийн дулааны станц"-аас "Замын-Үүд" чөлөөт бүс рүү татсан дулааны шугамд Замын-Үүд боомтын өргөтгөл, шинэчлэлийн явцад эвдрэл үүссэнээс үүдэн чөлөөт бүсийг дулаанаар хангах боломжгүй болсон асуудлын шалтгаан нөхцөлийг судлах, засвар үйлчилгээний зардлыг тооцох, үнэлгээ дүгнэлт гаргах, санал зөвлөмж | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх | | | | | боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 10, 05 дугаар сарын 06-ны өдрүүдэд Төрийн ордны Нутгийн удирдлагын танхимд зохион байгуулагдаж, батлагдсан удирдамж, хуралдааны шийдвэрийн дагуу холбогдох төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллагуудтай хамтран Замын-Үүд суманд 2025 оны 04 дүгээр сарын 23-28-ны өдрүүдэд дулааны шугамд үүссэн бодит гэмтлийг тогтоон ажилласан.<br>Дээрх ф900 дулааны хос шугамын гэмтлийн шалтгааныг тогтоож, засварын ажлын зураг, төсөвт өртгийг тооцож, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас, дулааны шугамын угсралт, чанар байдалтай холбоотой санал, дүгнэлтийг Эрчим хүчний яам, “Замын-Үүдийн дулааны станц”-аас тус тус ирүүлсэн ба ажлын хэсгийн ажилласан тайлан, санал, дүгнэлтийг Захирагчийн 2025 оны 01/340 тоот албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. | | |
| 1.1.8 | “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг 2025 оны III улиралд нээж байнгын ажиллагаанд шилжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө гаргаж, ажлыг эрчимжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл хувь | - | 100 | Ерөнхий төлөвлөгөө батлуулах, хил холболтын ажлууд удааширсантай холбоотой хойшлогдсон. | 0 | 0 |
| 1.1.9 | “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг нээхтэй холбоотой төсөв, санхүүжилтийн тооцоог | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт, хувиар | - | 100 | Ерөнхий төлөвлөгөө батлуулах, хил холболтын ажлууд удааширсантай холбоотой хойшлогдсон. | 0 | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж, дээд шатны байгууллагад танилцуулах, шийдвэрлүүлэх | | | | | | | |
| 1.2 | ЗГҮАХ 3.2.2.11 Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ. | | | | | | | |
| 1.2.1 | "Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн Монгол талын 900 га газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл, хувиар | - | 100% | Замын-Үүд чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаврыг төслийг боловсруулж, Шадар сайдын ажлын алба болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамдад хүргүүлэн холбогдох саналыг авсан ба саналуудыг тусган Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдаар батлуулж, Шадар сайдаар батлуулахаар хүргүүлсэн.<br>Замын-Үүд чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаврын дагуу Төрийн худалдан авах газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн болович төсвийн хэмнэлт хийхтэй холбогдуулан энэхүү төсөл арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. | 30% | 30 |
| 1.2.2 | "Замын-Үүд" чөлөөт бүс рүү салаа төмөр зам оруулах ТЭЗҮ хийлгэх санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл, хувиар | - | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай" Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийг холбосон төмөр зам барих ажлыг төлөвлөж, "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-г хэлэлцэн баталсан. Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 234 дүгээр "Говийн бүсийн эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор чөлөөт бүс чиглэлийн салбар төмөр замын төслийн техниз, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах асуудлыг судалж, | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулахыг Зам, тээврийн яаманд даалгасан ба энэхүү ажлын хүрээнд УБТЗ-аас гаргасан салбар төмөр зам барих техникийн нөхцөл болон бусад төлөвлөгөөний баримт бичгийг Зам, тээврийн яам, Монголын Төмөр зам ТӨХК-д тус байгууллагын 2025 оны 1/158 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 1.2.3 | Олон улсын чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийг Монгол Улсын чөлөөт бүсийн хуультай харьцуулсан судалгаа хийх, чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, дагалдан гарах дүрэм, журмын саналын төсөл, хуулийн үзэл баримтлал боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо, боловсруулсан эсэх Тийм 1\үгүй 0 | - | 1 | Олон улсын чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийг Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хуультай харьцуулсан судалгааг боловсруулж, 2025.09.11-нд захирагчид танилцуулав.<br>Үүнд:<br>-Бүгд Найрамдах Турк улсын “Чөлөөт бүсийн тухай хууль”<br>-Бүгд Найрамдах Казахстан Улсын "Тусгай эдийн засгийн болон үйлдвэрлэлийн бүсүүдийн тухай" хууль;<br>-БНСУ-ын Эдийн засгийн чөлөөт бүсийг тогтоох, удирдах тухай тусгай акт;<br>-БНХАУ-ын (Шанхай) туршилтын чөлөөт худалдааны бүсийн дүрэм. | 100% | 100 |
| **Хоёр. “Замын-Үүд” чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратеги зорилт** | | | | | | | | |
| **2.1.** Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилт | | | | | | | | |
| 2.1.1 | Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж “Замын-Үүд” чөлөөт бүсийн стратеги төлөвлөгөөг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан эсэх Тийм 1\үгүй 0 | - | 1 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж Шадар Сайдаар батлуулахаар 2025 оны 06-р сарын 03-ны 01/336 дугаар албан бичгээр Шадар Сайдад хүргүүлж 2025 оны 08-р сарын 27 өдөр Монгол Улсын шадар сайдаар батлуулсан. | 100% | 100 |
| 2.1.2 | 2026 онд Төсвийн хөрөнгө оруулалтаар чөлөөт бүсэд хийгдэх төсөл арга хэмжээний судалгаа хийж, санал боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан эсэх Тийм 1\үгүй 0 | - | 1 | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгах 3 арга хэмжээг тайлбар үндэслэлийн хамт боловсруулж 2025 оны 01-р сарын 13-нд Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.Үүнд: | 100% | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - “Замын-Үүд” чөлөөт бүс рүү салаа төмөр зам оруулах ТЭЗҮ, зураг төсөв хийлгэх<br>- Замын-Үүд чөлөөт бүсийн 1.2.5.6-р хэсэгт хийгдэх 2-р ээлжийн дэд бүтцийн авто зам, дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуургын зураг төсөвт тодотгол хийх, санхүүжилтийг шийдвэрлэх<br>- АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийг үргэлжлүүлэх. | | |
| 2.1.3 | Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Аж ахуйн нэгжийн тоо | - | 48 | “Замын-Үүд” чөлөөт бүсэд бүртгэлтэй үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлал, агуулахын зориулалтаар газар ашиглах эрх авч, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаа дууссан, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулан бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд үндсэн үйлдвэр, үйлчилгээний үйл ажиллагаагаа эхлүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл хүргүүлсэн.<br>Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд нийт 52 аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж ажиллаа.<br>Загвар зураг батлуулсан 30-н аж ахуйн нэгжүүд ажлын зураг хийлгэх, барилгын хөгжлийн төвөөр магадлал гаргуулах улмаар ажил эхлүүлэх зөвшөөрөл авахаар ажиллаж байна.<br>-Нийт хөрөнгө оруулагч компаниудаас үйл ажиллагаагаа эхлүүлсэн 11, Ажлын зураг хийлгэсэн 6 аж ахуйн нэгж 6-р сараас бүтээн байгуулалтын ажиллаа эхлүүлнэ.<br>-“Глобаль гров”, “Уушгийн агуй “, “Нэг зам нэг бүс нэг зорилго”, “Өсөх азот”, “Хатан тахилт чөлөөт бүс”, ХХК-ууд, иргэн Х.Доржсүрэн, Ү.Гантиг нар хөрсний болон геологийн шинжилгээ хийлгэсэн.<br>2025 оны 4-р сарын 1-ны дотор үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлэхгүй бол | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чөлөөт бүсийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дах хэсэг, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэл болгон газар эзэмших эрхийг хүчингүй болгож, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах тухай мэдэгдлийг Захирагчийн 2025 оны 02-р сарын 05-ны өдрийн 01/137, ... 01/191, 01/193 дугаар албан бичгээр 60-н аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. | | |
| 2.1.4 | Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэх, шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт хийж дээд шатны байгууллагад танилцуулах | Үйл ажиллагаа ны зардлаар | Төслийн тоо | - | 88 | 2016-2018, 2021 оноос эхлэн “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, хөрөнгө оруулагч иргэн, аж ахуйн нэгжтэй хийсэн Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт, биелэлтэд дүн шинжилгээ хийж тайлан боловсруулсан.<br>Тайлант хугацаанд чөлөөт бүсэд газар ашиглах эрх авсан 81 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 88 төсөл, үйл ажиллагаа эхлүүлсэн байдал, хөрөнгө оруулалтын гэрээг эрэмбэлж аж ахуйн нэгж тус бүрээр танилцуулга бэлтгэн Шадар сайдын ажлын албанд танилцуулсан. | 100% | 0 |
| 2.1.5 | Чөлөөт бүсэд бүртгэлтэй газар ашиглах эрх бүхий аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэх ажлыг үргэлжлүүлэн танилцуулга, тайлан боловсруулж дээд шатны байгууллагад танилцуулж шаардлагатай шийдвэрийг гаргах. | Үйл ажиллагаа ны зардлаар | Гэрээ, тоо | 75 | 81 | Чөлөөт бүсийн захирагчийн 2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/06 дугаар захирамжаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах заавар”, “Хөрөнгө оруулалтын гэрээний загвар”-т нэмэлт өөрчлөлт оруулж 2025 оны 03-р сарын 18-ны өдрийн А/13 дугаар захирамжаар шинэчлэн батлав.<br>Захирагчийн зөвлөлийн хурлаас 43 аж ахуйн нэгжийн гэрээг шинэчлэн байгуулах, талаар дахин удирдлагад танилцуулах шийдвэр гарсны дагуу аж ахуйн нэгжүүдтэй хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэн байгуулах, гэрээг сунгах ажлыг зохион байгуулж 43-н аж ахуйн нэгжүүдтэй холбогдож 26-н аж ахуйн нэгжтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулав. | 80% | 0 |
| 2.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилт | | | | | | | | |
| 2.2.1 | Чөлөөт бүсэд газар эзэмшиж буй иргэн, аж ахуй нэгжийн нэгж талбарт | Үйл ажиллага | Тайланги йн тоо | - | 31 | Газар ашиглах эрх үүсэж 5 жилийн хугацаа өнгөрсөн 28 аж ахуйн нэгжид газрын төлөв байдлын захиалгат хянан баталгааг хийлгүүлэх мэдэгдлийг хүргүүлсэн. Тухайн | 90.3% | 90.3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэж, тайланг баталгаажуулах | аны зардлаар | | | | байгууллагуудаас мэдэгдлийн дагуу хянан баталгааны тайлангийн дүгнэлтийг ирүүлээд байна.<br>-“Хан интернэйшнл чөлөөт бүс” ХХК, “Пологоулд” ХХК, “Шилэн хийц чөлөөт бүс” ХХК, “Чанг шэн олон улсын ачаа тээврийн чөлөөт бүс” ХХК, “Хатан тахилт чөлөөт бүс” ХХК, “Хас Си Ти чөлөөт бүс” ХХК, “Болгар Эй Ти чөлөөт бүс” ХХК, “Дижитал номадс чөлөөт бүс” ХХК, “Новоланд чөлөөт бүс” ХХК, "Домогт уул чөлөөт бүс" ХХК, "Наран бат элбэг мандала чөлөөт бүс" ХХК, "Көнигс чөлөөт бүс" ХХК, "Шайнинг хаус чөлөөт бүс" ХХК, "Оол Монголиа интернэшнл нетворк ви ай пи чөлөөт бүс" ХХК, “Болгар Эй Ти чөлөөт бүс” ХХК, “Билгүүн агар чөлөөт бүс” ХХК, "Глобал гров чөлөөт бүс" ХХК /худалдаа/, "Глобал гров чөлөөт бүс" ХХК /үйлдвэр/, "Глобал гров чөлөөт бүс" ХХК /ложистик/, "Өсөх Азод чөлөөт бүс" ХХК, "Вүүдхаус констракшн чөлөөт бүс" ХХК, "Саруул хангай чөлөөт бүс" ХХК, "Көнигс чөлөөт бүс" ХХК, "Жавхлант групп чөлөөт бүс" ХХК, "Хан интернэшнл чөлөөт бүс" ХХК, "Есөн хүүхэд чөлөөт бүс" ХХК, "Бүгэн эко чөлөөт бүс" ХХК, "Сансара трейд чөлөөт бүс" ХХК-иуд ашиглалтын газартаа мэргэжлийн эрх бүхий байгууллагаар газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааг хийлгүүлж, ерөнхий шинжээчээр батлуулан дүгнэлтийг | | |
| 2.2.2 | Газрын удирдлагын нэгдсэн системд чөлөөт бүсийн хуулийн дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх ажлыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газартай хамтран зохион байгуулах | Үйл ажиллагаа аны зардлаар | Хэрэгжилт, хувиар | - | 100% | Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан системийн хөгжүүлэлтийг хийх хүсэлтийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлж, 2024 оны 03 дугаар сарын 07, 04 дүгээр сарын 21-ний өдрүүдэд албан уулзалтыг зохион байгуулж, Чөлөөт бүсийн эрх зүйн байдалтай уялдуулан хөгжүүлэлт хийх сонгон шалгаруулалтыг зарласан.<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэгчээр “Эрхэт инноваци” ХХК нь захиалагчтай гэрээ байгуулан чөлөөт бүсийн газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, ногдуулалт, газар ашиглуулах гэрээний төсөл, цахим системийн өргөдлийн төрлүүд, | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар ашиглах хэлбэрийн өөрчлөлтүүдийн хөгжүүлэлтийн ажлыг дуусган хүлээлгэн өгсөн. Энэхүү хөгжүүлэлт хийгдсэний дагуу Газрын кадастрын цахим системд аж ахуйн нэгжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэж, газар ашиглах гэрээ, гэрчилгээг цахим хэлбэрээр үүсгэн, газар ашиглагчдад хүлээлгэн өгсөн. | | |
| 2.2.3 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн “Замын-Үүд” цахилгаан түгээх хэсэгтэй хамтран техникийн нөхцөл олгох | Үйл ажиллагааны зардлаар | Техникийн нөхцөл, тоо | - | 6 | Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт газар ашиглагч 12 аж ахуйн нэгжээс эхний хагас жилийн байдлаар тус байгууллагад эрчим хүч, ус, дулаан, бохир усны техникийн нөхцөл гаргуулах хүсэлт ирүүлснийг холбогдох хангагч байгууллагуудаас гаргуулах, холбогдох инженерийн хангамжийн трассын зураглалыг гаргаж хүргүүлсэн. | 100% | 100 |
| **Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | | |
| 3.1. | Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон тамхи худалдаалах энгийн зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг судалж ангилан, танилцуулж, үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах, сунгахгүй байх санал боловсруулж танилцуулах | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээний тоо | - | 1 | Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон тамхи худалдаалах энгийн зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг судалж, ангилан танилцуулга бэлтгэж, 2025.02 дугаар сард захирагчид танилцуулав. | 100% | 100 |
| 3.2. | Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах энгийн зөвшөөрөл, | Үйл ажиллагааны зардлаар | Тусгай зөвшөөрөл, тоо | - | 4 | -Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжээс тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирээгүй байна. | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | экспортлох зорилгоор уламжлалт технологиор согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлүүдийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн олгох | | | | | | | |
| **Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | | |
| 4.1.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилт | | | | | | | | |
| 4.1.1 | Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах; | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл, хувиар | - | 100% | 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хандан байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний удирдлагын мэдээллийн өөрчлөлтийг бүртгүүлсэн.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/07 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлж, баталгаажуулав.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”;“Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөө”;“Мэргэшил мэдлэгийг дээшлүүлэх 2025 оны сургалтын төлөвлөгөө”; “Дотоод хяналт зохион байгуулах 2025 оны төлөвлөгөө”-г боловсруулж, Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/08 дугаар захирамжаар батлуулсан.<br>Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн Х/77 дугаар албан бичгээр Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан ирүүлсний дагуу нэгжийн болон албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталгаажуулав. | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чөлөөт бүсүүдэд хөрөнгө оруулалтын төсөл сонгон шалгаруулах, төслийн хэрэгжүүлэх газар ашиглуулах (эзэмшүүлэх) тухай журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, Замын-Үүдийн дулааны станцаас чөлөөт бүс рүү татсан дулааны шугамын гэмтлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, засварын бодит тооцоог гаргах, буруутай этгээдийг олж тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулах тухай Монгол Улсын Шадар сайдын тушаалын төслийг тус тус боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны даргад хүргүүлсэн.<br>Захирагчийн ажлын албаны нийт албан хаагчдын 2025 оны ээлжийн амралтын саналыг нэгтгэн Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/03 дугаар захирамжаар баталсан.<br>Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Захирагчийн ажлын албаны 14 хоног тутмын хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг нэгтгэн тухай бүр Шадар сайдын ажлын албанд хүргүүлж байна.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсээс хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах чиглэлээр 2023-2024 онд хийсэн ажлын мэдээлэл, 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/208 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д нэмэлт оруулах тогтоолын төсөл, танилцуулга, яамдаас санал авах албан бичгийн төсөл;<br>Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр “Замын-Үүд”, “Алтанбулаг”, “Цагааннуур” чөлөөт бүсүүдэд хэрэгжүүлж болох төсөл, арга хэмжээний саналыг тус тус | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр, Чөлөөт бүсэд мөрдөх журмуудын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Шадар сайдын тушаалын төсөл боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 01/232 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд  хүргүүлсэн.<br>Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолын дагуу “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дотоод үйл ажиллагааг цахимжуулах ажлыг зохион байгуулж, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp.e-mongolia.mn/-д холбогдсон.<br>Захирагчийн ажлын албаны албан хаагчид чөлөөт бүсэд тогтмол ажиллах тухай шийдвэрийг гаргуулахаар Монгол Улсын Шадар сайдын тушаалын төсөл боловсруулан 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/224 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлэн батлуулсан.<br>- Захирагчийн ажлын албанаас өндөр насны тэтгэвэрт гарсан 4 ажилтан, ажлын албаны 1 ажилтанд тэтгэмж олгосон.<br>- Ажилтан албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн тайланг байгууллагын үнэлгээний баг хуралдан улирал бүр дүгнэн баталгаажуулж, зохих журмын дагуу урамшуулал олгох ажлыг зохион байгуулсан.<br>-  Ажилтан албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн тайланг үндэслэн, Монгол Улсын Шадар сайдад уламжлан 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгуулсан. Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/105 дугаар албан бичгээр хүсэлт гарган захирагчийн ажлын албаны 4 албан хаагчийг төрийн жинхэнэ албаны эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, төрийн албан хаагчийг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтуудад хамруулав.<br>Монгол - Хятад, Замын-Үүд - Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, “Замын-Үүд - Эрээний эдийн засгийн Хамтын ажиллагааны бүс (Монгол тал)”-ийн ерөнхий төлөвлөлт, “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг хооронд нь холбох, улсын хилийн шугамыг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох ажлын хэсгийн талаар танилцуулга бэлдэж, холбогдох материалын товьёг бэлдэж удирдлагад танилцуулсан.<br>2025 оны I улирлын байдлаар 7 албан хаагчийг албан тушаалд томилж, 4 албан хаагчийг өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлсөн байна. | | |
| 4.1.2 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны бүтцийн нэгжийн чиг үүргийг үйл ажиллагаатай уялдуулан дотоод зохион байгуулалт хийж санал танилцуулах | Үйл ажиллагааны зардлаар | Санал боловсруулсан эсэх Тийм 1/ үгүй 0 | - | 1 | Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 70 дугаар тушаалаар баталсан “Замын-Үүд” чөлөөт бүсийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу нийт ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр 01/71 дүгээр албан бичгээр хүргүүлэн батлуулсан.<br>- “Замын-Үүд” чөлөөт бүсийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулан Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 70 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг баримтлан нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 370, 371, 372 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрлийг авч, Захирагчийн 2025 оны 10 дугаар сарын | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 07-ны өдрийн А/57, А/58, А/59 дүгээр захирамжаар баталсан. Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Захирагчийн 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/62 дугаар захирамжаар баталсан. | | |
| 4.1.3 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт, хувиар | - | 100% | “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/08 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар “Дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөө”-г батлуулан биелэлтийг ханган ажиллав.<br>Замын-Үүд чөлөөт бүсийн Ажлын албаны нийт алба хаагчдын цаг ашиглалт, болон өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж 14 хоног тутам үр дүнгийн талаар тайланг нэгтгэж гаргав.<br>Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй захиргааны хэм хэмжээгээр, захирамж, журам, дүрэмд хяналт шинжилгээ хийж тайланг батлагдсан маягтын дагуу Шадар сайдын ажлын албан 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн.<br>- Чөлөөт бүсийн нийтлэг журмын төслийг Шадар сайдын ажлын албанд хүргүүлэх, шадар сайдын тушаалын төслийг боловсруулан Шадар сайдын ажлын албанд хүргүүлэв.<br>- Чөлөөт бүсийн тухай хууль, түүнийг дагалдан гарсан журам, дүрэм, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.<br>- Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 159 дүгээр тушаалаар “Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Хуралдааны тэмдэглэл болон албан даалгаврын хэрэгжилт, биелэлтэд судлагаа хийж, давхардал хийдэл, зөрчлийг арилгаж, уялдаа холбоог | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайжруулах арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж ажиллаж санал дүгнэлт боловсруулан ажилласан. | | |
| 4.1.4 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт, хувиар | - | 36% | Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар захирамжаар байгууллагын 2025 оны баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалт;<br>Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/07 дугаар захирамжаар байгууллагын 2024 оны баримт бичгийг архивлах ажлын удирдамж, архивд хүлээн авах хуваарийг тус тус боловсруулан батлуулсан.<br>• ХОХБХ-ээс 107 нэр төрлийн төслийн материал, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл зэрэг баримтуудыг цаасан хэлбэрээр хүлээн авсан байна.<br>• ДБХГХХ 2;<br>• ГЭЗХНХ 13;<br>• ГХХАМТХ 1;<br>• БСХ-ээс 7 боть баримтыг цаасан болон цахим хэлбэрээр архивд хүлээлгэн өгсөн.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба 2025 оны 01 сарын 01-ээс 12 сарын 10-ны байдлаар нийт 579ш албан тоотыг дээд газар, төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, хувь хүмүүс рүү хүргүүлсэн байна.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба 2025 оны 01 сарын 01-ээс 12 сарын 10-ны байдлаар нийт 466ш албан тоот ирсэн байна.<br>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой захирамж 97ш гаргасан.<br>Байгууллагын боловсон хүчинтэй холбоотой захирамж 65ш гаргасан. | 100% | 100 |
| 4.1.5 | Байгууллагын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, албан хаагчдыг чадавхжуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт, хувиар | - | 100% | Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. Монгол Улсын Ёс зүйн хорооны ажлын албатай холбогдож Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд нэвтрэх эрх авч, гишүүдийн бүртгэсэн. | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 02 дугаар сарын 20-ний өдөр Монгол Улсын Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран нийт албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, ёс зүйн дэд хорооны ажиллах журам” сэдвээр сургалт зохион байгуулсан. | | |
| 1004 .1.6 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээ авах | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээний тоо | - | 2 | - Замын-Үүд” чөлөөт бүсийн “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-г боловсруулан Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/08 дугаар захирамжаар батлуулсан.<br>- Захирагчийн ажлын албаны албан хаагчдын 2024 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь гаргуулж, тайланг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/218 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.<br>- 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/132, 2025 оны 11 дүгээр сарын дугаар албан бичгээр 2 иргэний ХАСУМ-ыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулсан. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр АТГ-ээс зохион байгуулсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем https://meduuleg.iaac.mn/ -ийг ашиглах тухай сургалтад хамрагдсан. | 100% | 50 |
| **4.2** Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилт | | | | | | | | |
| 4.2.1 | “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээг төлөвлөгөөтэй зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээ, тоо. | | 2 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Монгол, Хятад хэл дээр “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” сэтгүүлийг бэлтгэн нийт 300 хувь хэвлүүлэв.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын алба, Эрээн хотын чөлөөт бүсийн Захиргаа хамтран БНХАУ-ын Гуанжоу хотод 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулагдахаар төлөвлөж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ.<br>Үүнд: | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Форумд оролцох бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулав.<br>-Зарын постерыг бэлтгэн түгээлт хийв.<br>-Удирдлагын нээлтийн хэлэх үгийн төслийн боловсруулав.<br>-Арга хэмжээнд ашиглах баннерын зургийг бэлтгэн БНХАУ-ын талд хүргүүлэв.<br>-Арга хэмжээний үеэр дэлгэц дээр гарах видеоны зураг, текстийг бэлтгэн өгч ажиллалаа.<br>Байгууллагын цахим хуудас болох zfz.gov.mn сайт, фэйсбүүк хуудас Замын-Үүд чөлөөт бүс-Zamiin-Uud free zone гэсэн хаягуудад байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, зохион байгуулагдаж буй арга хэмжээг сурталчлах зорилгоор нийт 30 гаруй мэдээллийг бэлтгэн байршуулж /Шадар сайдын харьяа байгууллагуудын мэдээллүүдийг давхар түгээлт хийсэн/ ажилласан байна. 2025 оны эхний хагас жилийн байгууллагын цахим хуудсанд нийт 725916, гуравдугаар улирлын байдлаар 197900 нийт 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 1339395 хандалттай байна.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөххотод 2025 оны 08 дугаар сарын 25-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Эдийн засгийн хамтын ажиллагааны форум”-д 50 ширхэг танилцуулга материал илгээж, түгээлт хийсэн. /2025.08.21/<br>Монгол Улсын Шадар сайдын харьяа байгууллагуудын хоёрдугаар улирлын онцлох ажлуудыг сурталчлах ажлын хүрээнд Шадар сайдын Ажлын албаны зөвлөх А.Бүрэнбаатартай хамтран "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хийсэн онцлох ажлуудаас...гэсэн гарчигтай постерийн хийж, түгээлт хийв.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн хог хаягдал зайлуулах, тээвэрлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тендерийн “Үнэлгээний хороо”-ны нарийн бичгээр ажиллав. Тус ажлын хүрээнд холбогдох зарыг байршуулан, шалгарсан аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлж, дүгнэлт, тайланг албажуулав.<br><br>“Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хоёрдугаар хуралдаанаар 30 сэтгүүл, аж ахуйн нэгжүүдэд 20 сэтгүүл нийт 100 сэтгүүлийг тарааж, чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан. | | |
| 4.2.2 | Олон улсын чөлөөт бүсүүдтэй холбоо харилцаа тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээ, тоо. | - | 4 | Ирланд Улсын Шайнон чөлөөт бүсийн үйл ажиллагаа, хууль эрхзүйн орчны товч судалгааг хийсэн.<br>“Дэлхийн чөлөөт бүсүүдийн байгууллага”-аас 7 хоног бүр цахимаар дэлхийн чөлөөт бүсүүдийн талаарх мэдээлэл авч, хамтран ажиллаж байна.<br>БНХАУ-ын тэргүүний техник технологи үйлдвэрлэгч “Kedacom” компанитай хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоох, газар дээр нь очиж туршлага судлах чиглэлээр албан эмайл илгээсэн.<br>БНХАУ-ын СуЖоу хотын чөлөөт бүсийн хууль, эрхзүй, хөрөнгө оруулалтын орчны судалгааг урьдчилсан байдлаар боловсруулсан. | 100% | 0 |
| 4.2.3 | Чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл, мэдээллийг цахимжуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл, хувиар | - | 100 | Байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Юнивишн” ХХК-д Замын-Үүд суманд байрлах чөлөөт бүсийн Мэргэжлийн албадын нэгдсэн байранд хийгдэх шаардлагатай байгаа шилэн кабель, камерын тоо тэдгээрийн байршил, үнийн судалгааг хийж өгөх албан хүсэлтийг боловсруулан илгээсэн.Тус ажлын хүрээнд “Юнивишн” ХХК-тай “Хамтран ажиллах гэрээ” 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах “Замын-Үүд” чөлөөт бүсэд шилэн кабель татах, интернэт үйлчилгээ, VPN холболтын үйлчилгээг авав./2025.10.20/ | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн ажлын хэсгийн 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн хурлаар төрийн байгууллагын цахим шилжилттэй холбоотойгоор хийгдэх ажлуудыг хэлэлцсэн. Үүний дагуу байгууллагын бүх эд хөрөнгийг бүртгэн цахим хэлбэрт шилжүүлэх, компьютерын бүртгэлийн мэдээллийг цахимаар бүртгэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.<br><br>ЗҮ-15: “Олон чөлөөт бүсүүдийн хяналтын цонх хөгжүүлэх" ажлын цонхонд чөлөөт бүсэд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг шинээр байршуулах ажлыг зохион байгуулж, 91 аж ахуйн нэгжийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэв./2025.08.25-09.01/ | | |
| 4.2.4 | Чөлөөт бүсийн үйл ажиллагааг хөрөнгө оруулагчдад сурталчлах танилцуулга бэлтгэх | Үйл ажиллагааны зардлаар | Танилцуулга, тоо | - | 1 | -“Замын-Үүд” чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Монгол, Хятад хэл дээр “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” сэтгүүлийг бэлтгэн нийт 300 хувь хэвлүүлэв. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:<br>-“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын алба, Эрээн хотын чөлөөт бүсийн Захиргаа хамтран БНХАУ-ын Гуанжоу хотод 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулагдахаар төлөвлөж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ.<br>Үүнд:<br>-Форумд оролцох бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулав.<br>-Зарын постерыг бэлтгэн түгээлт хийв.<br>-Удирдлагын нээлтийн хэлэх үгийн төслийн боловсруулав.<br>-Арга хэмжээнд ашиглах баннерын зургийг бэлтгэн БНХАУ-ын талд хүргүүлэв. | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Арга хэмжээний үеэр дэлгэц дээр гарах видеоны зураг, текстийг бэлтгэн өгч ажиллалаа. | | |
| **4.3** Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилт | | | | | | | | |
| 4.3.1 | Батлагдсан төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд байршуулж тайлагнах; | Үйл ажиллагааны зардлаар | Шилэн дансанд тайлагнасан тайлан мэдээ, тоо | - | 171 | 2025 оны 12 дугаар сард үндсэн үйл ажиллагааны зардалд 1,468.3 сая төгрөг, байр ашиглалтын үйлчилгээнд 51,1 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 1,3 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс тус тус авсан. Үүнээс 12 сарын 10-ны өдрийн байдлаар тус санхүүжилтийн 1,066,4 сая төгрөгийн буюу 87,9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс:<br>• Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 811,1 сая төгрөг буюу 90,9 хувь<br>• Ажил олгогчоос НДШ-д төлөх 81,0 сая төгрөг буюу 61,4 хувь<br>• Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 61,1 сая төгрөг буюу 61,4 хувь<br>• Хангамж, бараа материалын зардалд 21,4 сая төгрөг буюу 100 хувь<br>• Урсгал засварын зардалд 11,4 сая төгрөг буюу 100 хувь<br>• Томилолт, зочны зардалд 3,2 сая төгрөг буюу 100,0 хувь<br>• Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 1,3 сая төгрөг буюу 100 хувь<br>Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны www.zfz.gov.mn "Шилэн данс", Сангийн яамны https://info,shilendans.gov.mn/ сайтад тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт хэтрэлтийн шалтгаан, цалингийн гүйлгээнээс бусад 5 сая төгрөгнөөс дээших үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээнүүдийг сар бүр мэдээлэх 171 мэдээг тус тус хуулийн хугацаанд нь тайлагнаж ил тодын хуулийг хэрэгжүүлэн ажилласан. | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.2 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн тодотголын санал хүргүүлэх, 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг эцэслэн боловсруулж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж батлуулах | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төсөв, мөнгөн дүн. | 2025 оны төсөв 1,771,378.100 төгрөг | 4,7 тэрбум төгрөг | 2025 оны төсөвт 7 дугаар сард төсвийн тодотгол хийгдэж төсвийн хуваарийг Шадар сайдын ажлын албанд хүргүүлж ажилласан.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны зохион байгуулалтын нэгжүүдээс 2026 төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд тусгах зардлын саналыг файл болон цаасаар хүлээн авч боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 05 өдрийн 01/343 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлж ажиллалаа.<br>2025 оны 11 сард УИХ-аас 2026 оны төсөв батлагдаж ирсэн. | 100% | 50 |
| 4.3.3 | Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллах; | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төсвийн зарцуулалт, хувиар | - | 100% | “Замын-Үүд” чөлөөт бүсийн хог хаягдал зайлуулах тээвэрлэх бэлтгэл ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган, тендерийн баримт бичиг, ажлын даалгавар, техникийн тодорхойлтыг тус тус боловсруулан Tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан тендер зарласан.<br>Сонгон шалгаруулалтаар “Ачлалт төмөр хэлхээ” ХХК шалгарч “Замын-Үүд” чөлөөт бүсийн хог хаягдал зайлуулах, тээвэрлэх ажил” гэрээг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан. 2025 оны төсөвт төсвийн тодотгол хийгдэж санхүүжилтийг хойшлуулснаас гэрээт ажил хугацаандаа хийгдээгүй. 2025 оны 8 дугаар 21-ны өдөр гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт хийгдсэн.<br>2025 оны 8 дугаарын сарын санхүүжилтээр урьдчилгаа төлбөрийг шилжүүлж гэрээт ажлыг эхлүүлсэн. Гэрээний гүйцэтгэл 70%-тай байгаа боловч Сангийн яамнаас төсвийг зогсоосон.<br>Замын-үүд чөлөөт бүсийн захирагчийн 2024 оны А/14 дугаар захирамжаар байгуулагдсан “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн гишүүд 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдөр хуралдаж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, хуримтлагдсан элэгдлээрээ анхны | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон 2 нэр төрлийн 100,220,157.36 төгрөгийн хөрөнгийг Шадар сайдын ажлын албаар уламжлуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх хүсэлтийг Захирагчийн 2025 оны 01/116 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор Үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасах зөвшөөрөл олгох тухай тогтоол гарч, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурал 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж, актлагдсан хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, сэлбэгд ашиглахаар Захирагчийн 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/10 дугаар захирамжаар данснаас хасаж санхүүгийн тайлан бүртгэлд тусгаж ажиллалаа.<br><br>Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах” зургийн даалгавар, тендерийн бичиг баримтын төслийг боловсруулж, Шадар сайдын ажлын албанд захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/127 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 4.3.4 | Аж ахуйн нэгжийн газрын төлбөр болон тэмдэгтийн хураамжийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Мөнгөн дүн | 48,1 сая төгрөг | 28,1 сая төгрөг | Захирагчийн 2025 оны А/06 дугаар захирамжаар “Замын-Үүд” чөлөөт бүсэд газар ашиглаж буй иргэн, аж ахуйн байгууллагын газрын жилийн төлбөрийн тооцоо батлуулсан. Үүнтэй холбоотой 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар газрын жилийн төлбөр 53,459,135.04 (тавин гурван сая дөрвөн зуун тавин есөн мянга нэг зуун гучин таван төгрөг дөрвөн мөнгө) төгрөг, үйлчилгээний хөлс, төлбөр, улсын тэмдэгтийн хураамж 2,209,500.00 (хоёр сая хоёр зуун есөн мянга таван зуу) төгрөг, Захирагчийн 2025 оны захирамжаар олгогдсон 28 нэгж талбарын газрын нэг удаагийн төлбөр 1,593,642,600.00 (нэг тэрбум таван зуун ерэн гурван сая | 100% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зургаан зуун дөчин хоёр мянга зургаан зуу) төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн захирамжаар олгогдсон 11 нэгж талбарын газарт Дорноговь аймгийн “Газрын харилцаа, хот байгуулалтын газраас газрын төлбөрийн ногдуулалтыг цахим системд үүсгэн, 2023-2025 оны 33,800,000.00 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн газрын орлогыг Захирагчийн 2025 оны 01/320 дугаар албан бичгийг тус байгууллага болон Замын-Үүд сумын Засаг даргад газарт тус тус хүргүүлэн дээрх орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. | | |
| 4.3.5 | “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг нээхтэй холбоотой ЗАА-ны зарим нэгж, мэргэжилтнүүдийг шилжүүлэн ажиллуулах бэлтгэл ажлыг хангах. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт, хувиар | - | 100% | - Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тушаалыг үндэслэн Захирагчийн ажлын албаны албан хаагчдыг чөлөөт бүсэд ажиллах, цахимаар болон албан байранд ирж ажиллах хуваарийг боловсруулан Захирагчийн 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/38 дугаар захирамжаар хуваарийн дагуу ажиллуулсан. | 100% | 100 |
| 4.3.6 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн 1.2.5.6-р хэсэгт хийгдэх 2-р ээлжийн дэд бүтцийн авто зам, дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуургын зураг төсөвт тодотгол хийх санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар дээд шатны байгууллагад санал хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Санал хүргүүлсэн эсэх Тийм 1\үгүй 0 | - | 1 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөний 2-р ээлжийн дэд бүтцийн авто зам, дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуургыг барих зураг төслийг 2013 онд хийгдсэн бөгөөд уг зураг төслийн төсвийг шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг 2026 оны улсын төсөвт тусгуулахаар 2025.05 сард Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. | 100% | 100 |
| | **Хэрэгжилтийн ерөнхий дүн (7 *зорилтын хүрээнд 38 арга хэмжээ*)** | | | | | Нийт 38 ажил төлөвлөсөн жилийн эцсийн хэрэгжилтийг биелэлттэй байна. | 91,8% | 75.4 |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

........................ /Х.ГАНХУЯГ/

(*албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧ ........................ /..................................../

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................